



## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

### Урамшууллын хэмжээг тогтоох тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 35 дугаар зүйлийн 35.17, 35.19, 35.20, 35.21 дэх хэсэг, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 04 дүгээр тогтоолоор баталсан мэргэжлийн хорооны ажиллах журмын 6 дугаар зүйлийн 6.3, 6.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх мэргэжлийн хорооны гишүүнд олгох урамшууллын хэмжээг эрх бүхий байгууллагаас тогтоосон сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр сар бүр тооцож, улирал тутам олгож байхаар тогтоосугай.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба (Г.Банзрагч)-нд даалгасугай.

ДАРГА



Д.ЭНХ-АМГАЛАН